

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын 3 дугаар үе шат төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/13/НА-СТА-ТХН

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Энхдалай
Утас: 2610512 Цахим хаяг: enkhdalai@audit.mn
Аудитор: Ж.Мөнхбилгүүн
Утас: 261740 Цахим хаяг: munkhbilguunj@audit.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн: Бэйкер Тилли Далайван Аудит ХХК-ийн
Захирал: Ц.Жигдэн
Утас: 70005401, Цахим хаяг: info@btdalaivanaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.1 Төслийн үйл ажиллагаа.....	9
3.2 Төсөл хэрэгжүүлэх нэгжийн гадаад, дотоод орчин.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн Хөгжлийн Банк
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.10 № 06/1035
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын 3 дугаар үе шат төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын 3 дугаар үе шат төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сангийн сайдын 2025 оны 174 дүгээр тушаалаар “Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжихэд мөрдөх түр журам” болон холбогдох бүтэц, орон тоог батлан 4 төсөл хэрэгжүүлэх нэгжийг 1 нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл 2”-оос шилжиж ирсэн А0305 улсын чанартай Ховд–Баян-Өлгий чиглэлийн авто замаас Эрдэнэбүрэн сум чиглэлийн 19.8 км, Ховд сум чиглэлийн 18.8 км авто замын үлдэгдэл ажлууд тайлант онд дууссан байна.

Дээрх авто замын барилгын ажлуудыг 2025 оны 2 дугаар сарын 24-ний өдөр Авто зам, зам байгууламжийг байнгын ашиглалтад авах ажлын хэсгийн №06/01/25, №06/02/25 дугаар акт, дүгнэлтээр хүлээн авч, үүрэг даалгаврын биелэлттэйгээр байнгын ашиглалтад оруулсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон тайлан

/төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10,558,202,405.36	12,330,679,986.39
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	8,677,420,615.35	2,269,539,207.11
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	8,677,420,615.35	2,269,539,207.11
31210	Төгрөг	136,087,955.76	12,233,769.34
31211	Төрийн сангийн харилцах	136,087,955.76	12,233,769.34
31220	Гадаад валют	8,541,332,659.59	2,257,305,437.77
31221	Төрийн сангийн харилцах	8,541,332,659.59	2,257,305,437.77
33	АВЛАГА	514,250.01	0.0
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	462,825.01	0.0
33500	Бусад авлага	51,425.00	0.0
34	УРЬДЧИЛГАА	6,216,000.00	10,043,398,246.28
34600	Урьдчилж гарсан зардал	0.0	10,043,398,246.28
34710	Урьдчилгаа тооцоо	6,216,000.00	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	20,000,000.00	17,742,533.00
35400	Хангамжийн материал	20,000,000.00	17,742,533.00
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	1,854,051,540.00	0.0
36800	Бусад эргэлтийн хөрөнгө	1,854,051,540.00	0.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	88,394,655.56.00	13,561,220,181.23
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	88,394,655.56.00	13,561,220,181.23
39200	Биет хөрөнгө	84,434,655.56.00	13,558,580,181.23
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	85,110,100.00	88,835,100
39206	Хуримтлагдсан элэгдэл	-675,444.44	-29,355,894.37
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	0.0	40,510,100
39208	Хуримтлагдсан элэгдэл	0.0	-2,284,759.19
39216	Дуусаагүй барилга, байгууламж	0.0	13,460,875,634.79
39300	Биет бус хөрөнгө	3,960,000.00	2,640,000.00
39301	Программ хангамж	3,960,000.00	3,960,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0.0	-1,320,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	10,646,597,060.92	25,891,900,167.62
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,514,318.19	5,008,073,074.46
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,514,318.19	5,008,073,074.46
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,514,318.19	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,644,082,742.73	20,883,827,093.16
51	Засгийн газрын хувь оролцоо	10,644,082,742.73	20,883,827,093.16
51200	Хуримтлагдсан үр дүн	10,644,082,742.73	20,883,827,093.16
51210	Өмнөх үеийн үр дүн	0.0	10,640,866,742.74

51220	Тайлант үеийн үр дүн	10,644,082,742.73	10,242,960,350.42
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	10,646,597,060.92	25,891,900,167.62

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон тайлан

/төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	10,878,843,629.36	10,567,288,851.28
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,878,843,629.36	10,567,288,851.28
120	Нийтлэг татварын бус орлого	10,878,843,629.36	10,567,288,851.28
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,878,843,629.36	10,567,219,031.28
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	10,878,843,629.36	10,567,219,031.28
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.0	69,820.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	268,195,447.65	505,690,277.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	268,195,447.65	505,690,277.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	268,195,447.65	505,690,277.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	211,919,893.94	323,268,109.8
210101	Үндсэн цалин	211,919,893.94	323,268,109.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,866,486.75	38,909,169.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,600,000.00	55,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,736,058.77	11,795,891.4
210401	Бичиг хэрэг	4,992,130.00	6,761,800.00
210402	Тээвэр, шатахуун	5,720.00	2,327,287.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,738,208.77	2,706,804.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	100,000.00	60,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	100,000.00	0.0
210602	Тавилга	0.0	60,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,212,340.00	26,150,766.00
210702	Дотоод албан томилолт	3,212,340.00	26,150,766.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	85,223.75	18,021,132.14
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.0	17,781,120
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	85,223.75	240,012.14
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	675,444.44	32,285,209.13
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	675,444.44	32,285,209.13
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	10,610,648,181.71	10,061,598,573.4
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	33,434,564.84	181,361,795.22
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	33,434,564.84	181,361,795.22
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3.82	18.2
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	3.82	18.2
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	33,434,561.02	181,361,777.02
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	10,644,082,742.73	10,242,960,350.42

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон тайлан

/төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	10,878,843,629.36	3,000,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,878,843,629.36	3,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,878,843,629.36	3,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,878,843,629.36	0.0
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	10,878,843,629.36	0.0
120009	Бусад орлого	0.0	3,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	291,650,711.28	517,072,937.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	291,650,711.28	517,072,937.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	291,650,711.28	517,072,937.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	211,207,939.4	322,753,809.32
210101	Үндсэн цалин	211,207,939.4	322,753,809.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,578,373.11	41,423,538.07
210201	Тэтгэврийн даатгалын зардал	16,200,562.73	30,617,398.7
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	1,806,269.85	3,602,046.79
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	1,300,000.00	935,500.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	654,308.11	935,500.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	2,617,232.42	5,333,092.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,600,000.00	55,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,736,058.77	9,468,604.4
210401	Бичиг хэрэг	4,992,130	6,761,800.00
210402	Тээвэр, шатахуун	20,005,720	0.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,738,208.77	2,706,804.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,316,000.00	44,295,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	100,000.00	3,725,000.00
210602	Тавилга	0.0	40,570,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,216,000.00	0.0
2107	Томилолт, зочны зардал	3,212,340.00	26,150,766.00
210702	Дотоод албан томилолт	3,212,340.00	26,150,766.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.0	17,781,120.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	10,587,192,918.08	-514,072,937.79
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,943,121,640.00	6,075,170,247.47
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,943,121,640.00	6,075,170,247.47
2200	Дотоод эх үүсвэрээр	1,943,121,640.00	6,075,170,247.47
220001	Барилга байгууламж	1,854,051,540.00	6,075,170,247.47
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,943,121,640.00	-6,075,170,247.47

14	Бусад эх үүсвэр	33,434,564.84	181,361,795.22
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	33,434,564.84	181,361,795.22
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	85,227.57	18.20
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	85,227.57	18.20
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	33,349,337.27	181,361,777.02
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	8,677,420,615.35	-6,407,881,408.24
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	8,677,420,615.35
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,677,420,615.35	2,269,539,207.11

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон тайлан

/төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12- р сарын 31- нээрх үлдэгдэл	0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	10,644,082,742.73	10,644,082,742.73
10	2024 оны 12- р сарын 31- нээрх үлдэгдэл	10,644,082,742.73	10,644,082,742.73
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-3,215,999.99	-3,215,999.99
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,640,866,742.74	10,640,866,742.74
19	Тайлант үеийн үр дүн	10,242,960,350.42	10,242,960,350.42
20	2025 оны 12- р сарын 31- наарх үлдэгдэл	20,883,827,093.16	20,883,827,093.16

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон тайлан

/төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,238,716,000.00	17,159,462,216.54	79,253,783.46	99.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	593,716,000.00	517,072,937.79	76,643,062.21	87.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	593,716,000.00	517,072,937.79	76,643,062.21	87.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	374,533,000.00	322,753,809.32	51,779,190.68	86.2
210101	Үндсэн цалин	374,533,000.00	322,753,809.32	51,779,190.68	86.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,925,000.00	41,423,538.07	8,501,461.93	82.9
210201	Тэтгэврийн даатгал	33,949,000.00	30,617,398.70	3,331,601.30	90.2
210202	Тэтгэмжийн даатгал	3,994,000.00	3,602,046.79	391,953.21	90.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,997,000.00	935,500.00	1,061,500.00	46.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,997,000.00	935,500.00	1,061,500.00	46.8
210205	Эрүүл мэндийн даатгал	7,988,000.00	5,333,092.58	2,654,907.42	66.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,200,000.00	55,200,000.00	-	100.0

Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын 3 дугаар үе шат төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	1,200,000.00	1,200,000.00	-	100.0
210304	Байрны түрээс	54,000,000.00	54,000,000.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	10,846,000.00	9,468,604.40	1,377,395.60	87.3
210401	Бичиг хэрэг	6,766,000.00	6,761,800.00	4,200.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,250,000.00	2,706,804.40	543,195.60	83.3
210404	Ном, хэвлэл	830,000.00	-	830,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,110,000.00	44,295,100.00	2,814,900.00	94.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,410,000.00	3,725,000.00	2,685,000.00	58.1
210602	Тавилга	40,700,000.00	40,570,100.00	129,900.00	99.7
2107	Томилолт, зочны зардал	38,320,000.00	26,150,766.00	12,169,234.00	68.2
210702	Дотоод албан томилолт	38,320,000.00	26,150,766.00	12,169,234.00	68.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,782,000.00	17,781,120.00	880.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,782,000.00	17,781,120.00	880.00	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,645,000,000.00	16,642,389,278.75	2,610,721.25	100.0
220001	Барилга байгууламж	16,645,000,000.00	16,642,389,278.75	2,610,721.25	100.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(17,238,716,000.00)	(17,159,462,216.54)	(79,253,783.46)	99.5
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	17,238,716,000.00	17,159,462,216.54	79,253,783.46	99.5
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	6,592,243,185.26	(6,592,243,185.26)	-
72	ЗГ-ын зээл	16,593,716,000.00	10,567,219,031.28	6,026,496,968.72	63.7
722	Гадаад	16,593,716,000.00	10,567,219,031.28	6,026,496,968.72	63.7
7221	Төслийн зээл	16,593,716,000.00	10,567,219,031.28	6,026,496,968.72	63.7
322101	Шинээр авах	16,593,716,000.00	10,567,219,031.28	6,026,496,968.72	63.7
	Төсвийн гүйцэтгэлийн тохируулга		(184,361,777.02)	(184,361,777.02)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	8,677,420,615.35	(8,677,420,615.35)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,269,539,207.11	(2,269,539,207.11)	
6	Байгууллагын тоо	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	Ажиллагсдын тоо	9	6	3	66.7
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	8	5	3	62.5

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төслийн үйл ажиллагаа

Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын 3 дугаар үе шатны төсөл нь улсын чанартай авто замын ангилалд багтах Улаангом-Ховд, Улиастай-Алтай чиглэлийн шороон замыг хатуу хучилттай болгож сайжруулснаар зам хэрэглэгчид цаг агаарын ямар ч нөхцөлд авто замаар саадгүй зорчих боломжийг хангах, тээвэр логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, ачаа болон зорчигч тээврийг нэвтрүүлэх, тээврийн зардлыг бууруулах, аялал жуулчлал хөгжүүлэх, бүс нутгийн ард иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, экспортыг нэмэгдүүлснээр цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлэх зорилготой үйл ажиллагаа явуулж байна.

Төслийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- I. Төслийн авто замуудыг барих
 - 1а. Ховд-Улаангом чиглэлийн 163 км авто замын барилгын ажил, 3 багц
 - 1б. Улиастай-Алтай чиглэлийн 178 км авто замын эхний 40 км (Улиастай-Цагаанхайрхан) авто замын барилгын ажил
- II. Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй авто замын хөрөнгийн менежментийн тогтолцоог сайжруулах;
- III. Авто замын аюулгүй байдлын төлөвлөлт болон системийг сайжруулах;
- IV. Эрдэнэбүрэн, Ховд чиглэлийн авто зам барих ажил
 - 4а. А0305 улсын чанартай Ховд- Баян-Өлгий чиглэлийн авто замаас Эрдэнэбүрэн сум чиглэлийн 19.776 км авто замын ажил;
 - 4б. А0305 улсын чанартай Ховд-Баян-Өлгий чиглэлийн авто замаас Ховд сум чиглэлийн 18.755 км авто замын ажил гэсэн үндсэн дөрвөн бүрэлдэхүүн хэсэгтэй байна.

3.2 Төсөл хэрэгжүүлэх нэгжийн гадаад, дотоод орчин

Монгол Улсын Засгийн газар, Азийн Хөгжлийн Банк хооронд 2023 оны 10 дугаар сарын 5-ны өдөр 150.0 сая ам.долларын зээлийн гэрээнд гарын үсэг зурсан байна. Төсөл, арга хэмжээний нийт санхүүжилт 158.0 сая ам.доллар бөгөөд санхүүжилтийн эх үүсвэр нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- АХБ-ны хөнгөлөлттэй зээл (4342-МОН) – 30.0 сая ам.доллар
- АХБ-ны энгийн зээл (4343-МОН) – 120.0 сая ам.доллар
- МУЗГ (НӨАТ болон гаалийн албан татварын чөлөөлөлт) – 8.0 сая ам.доллар

Зам тээврийн хөгжлийн сайдын 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн А/126 тушаалаар Төслийн удирдах хороог байгуулах шийдвэр гаргаж, Төслийн удирдах хорооны даргаар Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, төслийн захирлаар тус яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын даргыг томилсон байна.

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн орон тоог Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 227 дугаар тушаалаар 9 байхаар баталжээ

Тус төсөл нь Авто тээврийн тухай хууль, Авто замын тухай хууль Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм журмуудыг дагаж мөрддөг байна.

Тайлант хугацаанд төслийн санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5-д “Төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно.”
- Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн А/3 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- Сангийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 174 тоот “Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжихэд мөрдөх түр журам”.

Төслийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөтэй гэж үнэллээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудиторын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын 3 дугаар үе шат төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсөл нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлагналд Төсвийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн боловсруулсан Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 21 дүгээр бүлэг “Гадаад зээл, тусламжийн бүртгэл”, Сангийн сайдын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ыг тус тус мөрддөг байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын 3 дугаар үе шат төслийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15,245,303.1 мянган төгрөгөөр буюу 1.4 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	8,677,420.6	2,269,539.2	(6,407,881.4)
Авлага	514.2	-	(514.2)
Урьдчилгаа	6,216.0	10,043,398.2	10,037,282.2
Бараа материал	20,000.0	17,742.5	(2,257.5)
Үндсэн хөрөнгө	1,942,446.2	13,561,220.2	11,618,774.0
Нийт хөрөнгө	10,646,597.1	25,891,900.2	15,245,303.1
Богино хугацаат өр төлбөр	2,514.3	5,008,073.0	5,005,558.7
Хуримтлагдсан үр дүн	10,644,082.7	20,883,827.1	10,239,744.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10,646,597.1	25,891,900.2	15,245,303.1

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, урьдчилгаа, үндсэн хөрөнгө, өр төлбөр болон хуримтлагдсан үр дүнгийн данстуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,269,539.2 мянган төгрөгт хүрч, 6,407,881.4 мянган төгрөгөөр буурсан нь авто замын ажлын гүйцэтгэлд 6,074,930.2 мянган төгрөг, үндсэн хөрөнгө худалдан авахад 44,235.1 мянган төгрөг, үйл ажиллагааны зардалд 288,716.1 мянган төгрөг зарцуулсан нь нөлөөлсөн байна.
- Урьдчилж төлсөн төлбөр дансны үлдэгдэл 10,037,282.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Улиастай-Цагаанхайрхан 40 км авто замын болон Ховд-Улаангом 163 км авто замын гүйцэтгэгч компаниудад урьдчилгаа төлбөр олгосон;

- Үндсэн хөрөнгө тайлант онд дуусаагүй барилга байгууламж 11,606,824.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн;
- Өр төлбөр 5,005,558.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь гэрээний дагуу суутгаж авсан барьцаа төлбөр болон гэрээт ажлын төлбөр нөлөөлсөн байна.
- Хуримтлагдсан үр дүн дансны өсөлтөд тайлант үеийн үйл ажиллагааны үр дүн нөлөөлжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын 3 дугаар үе шат төслийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг гадаадын зээлээс 49,668,107.2 мянган төгрөгөөр бүрдүүлж, хөрөнгийн зардалд 48,769,917.2 мянган төгрөг, урсгал зардалд 898,190.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, батлуулсан байна.

Тайлант онд тодотголоор батлагдсан төсвийг 33,074,391.2 мянган төгрөгөөр бууруулж, гадаадын эх үүсвэрээс 16,593,716.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр гадаадын эх үүсвэрээс 10,567,219.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс 6,592,243.2 мянган төгрөг, нийт 17,159,462.2 мянган төгрөгийн эх үүсвэрээр хөрөнгийн зардалд 16,642,389.3 мянган төгрөг, урсгал зардалд 517,072.9 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Төсвийн зардал 17,159,462.2 мянган төгрөг буюу 99.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: цалин, НДШ-ийн зардалд 364,177.3 мянган төгрөг, байр ашиглалтын зардалд 55,200.0 мянган төгрөг, томилолтын зардалд 26,150.8 мянган төгрөг, хангамжийн зардалд 9,468.6 мянган төгрөг, эд хогшил засварын зардалд 44,295.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнд 17,781.1 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 16,642,389.3 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
70207	Гадаад зээлээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр	17,238,716.0	17,159,462.2	79,253.8	99.5
80104	Үйл ажиллагааны зардал	593,716.0	517,072.9	76,643.1	87.1
80918	Хөрөнгө оруулалтын зардал	16,645,000.0	16,642,389.3	2,610.7	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа.

Үүнд:

- o Сангийн Сайдын 2023 оны 12 дугаар сарын 227 дугаар тушаалаар тус төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог 9 байхаар баталсан ч 2024-2025 онуудад 6 ажиллагсадтай үйл ажиллагаа явуулсан. Цалингийн зардалд 374,533.0 мянган төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 322,753.8 мянган төгрөг буюу 86.2 хувийг зарцуулсан байна.
- o Тус төслийн албан хаагчдад хоол унааны мөнгө олгоогүй, гадаад томилолтын зардал, төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал болон сургалт семинар, хурал зөвлөгөөний зардал, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ хийгдээгүй, төлбөр гараагүй байна.

- Төслийн үйл ажиллагаандаа нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргахад зориулагдсан 3,960.0 мянган төгрөгийн үнэтэй, Ординат ХХК-ийн Unicus санхүүгийн программ хангамжийг ашиглаж байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 4 хөтөлбөрийн 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төслийн ерөнхий төлөвлөгөөний үйл ажиллагааны хэрэгжилтийн түвшин 4.3 хувьтай байна. 2025 онд 49 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 43 арга хэмжээ 100 хувь, 2 арга хэмжээ нь 50-90 хувьтай хэрэгжиж, 4 арга хэмжээг 2026 онд хэрэгжүүлэхээр хойшлуулсан байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

(сая ам.доллар)

Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний нэр		Төсөвт өртөг	Зарцуулсан	Хувь
1	Бүрэлдэхүүн хэсэг 1. Авто замын нөхцөл байдал сайжирна.			
1.1	Ховд-Улаангом чиглэлийн 163 км хатуу хучилттай авто замын барих	69,300.0	250.5	0.4
1.2	Улиастай-Цагаанхайрхан чиглэлийн 40 км авто замын барих	29,000.0	2,558.5	8.8
1.3	Цагаанхайрхан - Алтай чиглэлийн 138 км авто замын шинэчилсэн инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах	270.0	63.8	23.6
1.4	Цагаанхайрхан - Цагаанчулуут чиглэлийн 60 км авто замын барилгын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулалт	23,800.0	-	-
1.5	Ховд - Улаангом, Улиастай - Алтай чиглэлийн авто замуудад техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх	5,000.0	83.5	1.7
1.6	Ховд-Баян Өлгий чиглэлийн А0305 дугаартай улсын чанартай авто замаас Эрдэнэбүрэн хүртэлх 19.776 км авто замын барилгын ажил	838.0	627.4	74.9
1.7	Ховд-Баян Өлгий чиглэлийн А0305 дугаартай улсын чанартай авто замаас Ховд хүртэлх 18.755 км авто замын барилгын ажил	1,927.0	1,711.2	88.8
1.8	Ховд-Баян Өлгий чиглэлийн А0305 дугаартай улсын чанартай авто замаас Ховд сум, Эрдэнэбүрэн сум чиглэлийн авто замуудад техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх	196.1	196.1	100.0
1.9	Төслийн байгаль орчны үйл ажиллагаанд хөндлөнгийн мониторинг хийх зөвлөх үйлчилгээ	100.0	-	-
2	Бүрэлдэхүүн хэсэг 2. Цаг уурд тэсвэртэй авто замын хөрөнгийн менежмент сайжрах (CS2).			
2.1	Газар зүйн мэдээллийн системийн программ хангамжид суурилсан авто замын хөрөнгийн менежментийн тогтолцооны мэдээллийн санг өргөтгөж хөгжүүлэх, судалгааны ажлыг гүйцэтгэх	1,000.0	-	-
2.2	Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох удирдамж, уур амьсгалын өөрчлөлтөөс үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах бодлогын танилцуулга боловсруулах	-	-	-
2.3	Зам арчлалт, засварын ажлын төлөвлөлтийн шийдвэр гаргахад туслах программ хангамжийн хэрэгслүүдийг үүсгэж, хөгжүүлэх	-	-	-
2.4	Авто замын хөрөнгийн менежментийн тогтолцооны программ хангамжийг ашиглах чадавхыг бэхжүүлэх сургалт зохион байгуулах	-	-	-
2.5	Зам, засварын ажлыг үе шаттай хэрэгжүүлэх, санхүүжилтийн түвшин, сүлжээний ашиглалтын байдлыг сэргээж хэвийн байдал оруулах зэрэг хөтөлбөрийг багтаасан замын зураглал болон замын санд хөрөнгө төвлөрүүлэх зөвлөмжийг боловсруулах	-	-	-
3	Бүрэлдэхүүн хэсэг 3. Авто замын аюулгүй байдлын төлөвлөлт болон системийн сайжруулах ажлыг гүйцэтгэх			
3.1	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тогтолцооны талаарх мэдлэгийг дээшлүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийх чадвар эзэмшүүлэх, аудит хийх журам боловсруулах чиглэлээр сургалт зохион байгуулах	-	-	-
3.2	Авто замын зураг төслийн шатанд болон авто замын ашиглалтад өгөхийн өмнөх шатанд замын хөдөлгөөний аюулгүй байдалд "Замын нөхцөл байдлыг үнэлэх олон улсын хөтөлбөрийн iRAP 3 од"-ын үзүүлэлтээр аудит хийх	-	-	-
3.3	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм, журмыг дагаж мөрдөх талаар олон нийтэд сургалт хийх	-	-	-
4	Бүрэлдэхүүн хэсэг 4. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаа			
4.1	Зээлийн гэрээ болон батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу төсөл, арга хэмжээг хугацаанд нь үр дүнтэй хариуцан хэрэгжүүлэх, нэгдсэн зохицуулалтаар хангах	1,430.0	260.4	18.2
4.2	Төслийн санхүүгийн тайланд аудит хийлгэж, тайлагнах	40.0	-	0.0
НИЙТ ДҮН		132,901.1	5,751.4	4.3

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын 3 дугаар үе шатны төсөл нь ТУХ-ны 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар 2025 онд төслийн ажлын хүрээнд нийт 94,208.0 мянган ам.долларын 5 худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 2 зөвлөх үйлчилгээ нь Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 81 дүгээр тогтоолоор Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор гадаад зээлийн хөрөнгөөр зөвлөх үйлчилгээ, төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардал зэрэг урсгал зардлыг санхүүжүүлэхгүй байх чиглэлтэй холбогдуулан цаашид хэрхэн шийдэгдэх нь тодорхойгүй байна.

Ховд-Улаангом чиглэлийн 163 км хатуу хучилттай авто замын олон улсын нээлттэй сонгон шалгаруулалт 3 багцтайгаар 2024 онд зохион байгуулагдаж, Багц-1-т “Чайна роуд энд бридже корпорашн” компани, Багц-2,3-т “Люнзъяан роуд энд бридж” компани тус тус шалгарч, 55,631.7 мянган ам.долларын гэрээг 2025 оны 7 дугаар сард байгуулсан байна.

Улиастай-Алтай чиглэлийн 178 км авто замын Цагаанхайрхан-Цагаанчулуут хэсгийн 60 км авто зам барих ажил нь авто замын инженерийн нарийвчилсан зураг төслийн баримт бичгийн магадлалын ерөнхий дүгнэлт экспертизээр баталгаажсаны дараа гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажил эхлэхээр хүлээгдэж байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын 3 дугаар үе шат төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн энэхүү тайланд төслийн нэгжийн үйл ажиллагааг сайжруулах, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг тодруулгын хамт иж бүрэн толилуулах, ажил гүйлгээг анхан шатны хүчин төгөлдөр ибаримтад үндэслэн бүртгэх талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Бэйкер Тилли Далайван Аудит ХХК-ийн аудитор Ц.Уртнасан, аудиторын туслах Г.Халиун нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер М.Болормаа, компанийн ерөнхий захирал Ц.Жигдэн нар анхан шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, Үндэсний аудитын газрын санхүүгийн аудитын газрын Аудитор Ж.Мөнхбилгүүн, менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус дараагийн шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын 3 дугаар үе шат төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 07/393 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 508,906.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож, 5,089.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл 3 дугаар үе шат төсөл нь 2025 онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор томилолтын зардлыг 12,169.3 мянган төгрөгөөр, шуудан холбоо, интернэтийн зардлыг 543.2 мянган төгрөг, ном хэвлэлийн зардлыг 830.0 мянган төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардлыг 2,814.9 мянган төгрөг, нийт 16,357.4 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 25 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулбал зохих цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5,785,616.0 мянган төгрөгийн 12 мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын 3 дугаар үе шат төслийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3,216.0 мянган төгрөгийн зөрчилд тогтоосон 1 төлбөрийн актыг бүрэн барагдуулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	3,216.0	1	3,216.0	100.0
Нийт дүн	1	3,216.0	1	3,216.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дараагийн аудитаар авч үзэхээр шийдвэрлэсэн. Үүнд

Дараагийн аудитаар Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын III үе шатны төслийн хүрээнд хэрэгжиж буй Ховд–Улаангом чиглэлийн 163 км хатуу хучилттай авто зам, Улиастай-Цагаанхайрхан чиглэлийн 40 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилтэд аудитын нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,011,289.1 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулсан. Үүнд:

- Гүйцэтгэгч байгууллагын барилга угсралтын ажлын санхүүжилтээс гэрээний дагуу 5%-ийн барьцаа суутгаж авдаг бөгөөд суутгасан 947,218.1 мянган төгрөгийн барьцаа хөрөнгийг бүртгээгүй байна. Мөн тайлант хугацаанд гүйцэтгэсэн ажлын олгоогүй санхүүжилт 4,060,854.9 мянган төгрөгийн өр төлбөрийг бүртгэлд тусгаагүй.
- Өмнөх оны аудитаар тогтоосон төлбөрийн акт 3,216.0 мянган төгрөгийг ажилтны цалингаас суутган төлсөн бөгөөд цалингийн зардлаар давхардуулан бүртгэсэн байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар 5.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: "5.1.4.үнэн зөв байх; 12 дугаар зүйлийн 12.2 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:", 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 14 дүгээр зүйлийн 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ 14.4.3 бүх өр төлбөр" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар илэрсэн 901,384.8 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

1. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус төсөл нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг тодруулгын хамт иж бүрэн толилуулаагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх зааврын 8.2."Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч УСНББОУС-аар шаарддаг мэдээллийг тодруулна, 8.5.3."Санхүүгийн тайлан болон мөрийн зүйлс нэг бүрийг толилуулсан дэс дарааллын дагуу санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулсан зүйлсийн талаарх дэмжих мэдээлэл болон бусад тодруулга" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам болон бусад холбогдох дүрэм журмыг баримтлан санхүүгийн тайланг тодруулгын хамт иж бүрэн толилуулах.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

2025 оны 9 дүгээр сард гарсан томилолтын зардлаас 530.2 мянган төгрөгийн шатахууны зардал, зөвлөх үйлчилгээний ажлын төлбөрийн 900,854.6 мянган төгрөгийн гүйлгээний и-баримт цахим системд бүртгэгдээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Нэмэгдсэн өртгийн албан

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

татварын тухай хуулийн 14.3-т “Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ.” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тасалбар болголт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Худалдан авалтын цахим төлбөрийн баримтыг бүртгүүлж, анхан шатны баримтыг бүрдлийг хангаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/			
							Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
						Тоо	Дүн	Тоо	Дүн	
Гүйцэтгэгч байгууллагын барилга угсралтын ажлын санхүүжилтээс гэрээний дагуу суутгасан 5%-ийн барьцаа 947,218.1 мянган төгрөг, мөн тайлант хугацаанд гүйцэтгэсэн ажлын олгоогүй санхүүжилт 4,060,855.0 мянган төгрөгийн өр төлбөрийг бүртгэлд тусгаагүй байна.	1	5,008,073.1	1	5,008,073.1			1	5,008,073.1		
Өмнөх оны аудитаар тогтоосон төлбөрийн акт 3,216.0 мянган төгрөгийг ажилтны цалингаас суутган төлсөн бөгөөд цалингийн зардлаар давхардуулан бүртгэсэн байна.	1	3,216.0			1	3,216.0	1	3,216.0		
Дүн	2	5,011,289.1	1	5,008,073.1	1	3,216.0	2	5,011,289.1		

6.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төслийн нэгжийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг тодруулгын хамт иж бүрэн толилуулаагүй байна.	1						1	
2	2025 оны 9 дүгээр сард гарсан томилолтын зардлаас 530.2 мянган төгрөгийн шатахууны зардал, зөвлөх үйлчилгээний ажлын төлбөрийн 900,854.6 мянган төгрөгийн гүйлгээний и-баримт цахим системд бүртгэгдээгүй байна.	1	901,384.8					1	901,384.8
	Дүн	2	901,384.8					2	901,384.8